

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2024/17 дүгээр албан бичгийн нэгдүгээр хавсралт



**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НИЙСЛЭЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ”-ИЙН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2024 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түшин	Хүрэх түвшин	Биелэлт	Хэрэгжилт (хувь)
1	2	3	4	5	6	7
НЭГ. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ДЭД БОЛОН САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ						
1	8.Дүүргийн соёлын төв, спорт заалыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нээлттэй болгож, тэднийг спорт, соёл, урлагаар хичээллэх боломжийг хангах, дугуйлан, секцэд хамруулах, төрөл бүрийн спорт, урлаг, соёлын уралдаан, тэмцээн зохион байгуулахад заал, танхимаар хангах	Хэрэгжилтийн хувь	100	100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр спорт заал, зориулалтын талбайг нээлттэй, үнэгүй ашиглуулах, секц дугуйланг шинээр байгуулах чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж зөвлөмж гарган дүүргийн Биеийн тамир, спортын хороодод 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 02/71 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Энэ хүрээнд 2024 онд Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Хан-Уул, 7 дүүргийн биеийн тамир, спортын хороод ашиглалтыг нь хариуцаж байгаа 7 спорт цогцолбор, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа 7 спорт заал, 2 усан бассейнд үнэ төлбөргүйгээр 7 хоног бүр хуваарьт цаг гарган нийт 55 байгууллагын 642 иргэнд тогтмол үйлчилгээ үзүүлэн ажилласан. Даам, хонхтой бөмбөг, бочи, хэрэглэлтэй сэлэм, фитнес, суугаа волейбол, ширээний теннис, туялзуур сэлэм, тусгай олимпын төрөл, пара бадминтон гэсэн 10 төрлөөр секц, дугуйланг хичээллүүлж 21 байгууллагын 160 иргэнийг тогтмол хичээллүүлсэн.	100

1	2	3	4	5	6	7
ХОЁР. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:						
2	10.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, тэднийг идэвхжүүлэх спортын өдөрлөг, тэмцээн уралдааныг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	4	5	<p>Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг биеийн тамир, спортын тэмцээн, уралдаанд тэгш хамруулах чиглэлээр дүүргийн биеийн тамир, спортын хороодод үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд нийслэл, дүүргийн хэмжээнд нийт 42 арга хэмжээ зохион байгуулж 664 байгууллагын 2404 иргэн хамрагдаж нийт 46.637.100 төгрөгийг зарцуулсан. Үүнээс: Улаанбаатар хотын аварга шалгаруулах пара бадминтон, пара бочи, хонхтой бөмбөгийн төрлүүдээр зохион байгуулж 23 байгууллагын 115 тамирчин оролцож улсын төсвөөс 4,800,000.0 төгрөгийг зарцуулсан.</p> <p>“Улаанбаатар марафон 2024” олон улсын гүйлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийн 7 ангилал (тусгай олимпын төрөл 500 м -т 36 хүн, 800 м -т 20 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1500 м -ийн зайд (хараагүй) 34 хүн, (тэргэнцэртэй) 17 хүн, 21,095 км -т 30 тамирчин, 42,195 км -т 10 тамирчин, гар дугуйн ангилалд 5 тамирчин)-д нийт 152 хүн оролцсон. Тус марафонд тусгай олимпын төрлийг 500м, 800 метрийн зайн ангиллаар нэмж оруулсан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 42,195 м, 21,09 5 метрийн зайн ангилалд олгодог шагналын санг 50 хувиар нэмэгдүүлж гүйлтэд байр эзэлсэн тамирчдад олгосон.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1048, А/1086 дугаар захирамж, Автомашины хэрэглээнээс үүдэлтэй сөрөг нөлөөг багасгахад олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор “Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрлийн төлөөлөл болгож Монголын пара бадминтон, Монголын суугаа волейболын холбоотой хамтран үзүүлэх тоглолтуудыг хийж тухайн спортын</p>	100

1	2	3	4	5	6	7
					төрлүүдийг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.	
Хэрэгжилтийн дундаж хувь:						100%

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С.САРАНЦЭЦЭГ

Г.БЯМБАСАЙХАН

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02/1664 дүгээр албан бичгийн хоёрдугаар хавсралт



"ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ БОЛОН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ТУСГУУЛАХ САНАЛ

2024 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
	1	2	3	4	5	6	7
1.Сургалт, сурталчилгааны чиглэлээр:							
1.1.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгэмшүүлэх, спортоор хичээллэх боломжийг бүрдүүлэх, тэднийг идэвхжүүлэх, нийгмийн сөрөг хандлагыг өөрчлөх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор спортын төрлүүдийг танилцуулах өдөрлөгийг зохион байгуулна.	Спортын өдөрлөгийг зохион байгуулсан тоо	2	10	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод, бусад байгууллагууд	II-III улирал
1.2.	Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт хүнд зориулсан секц дугуйлангуудын судалгаа гаргаж хичээллэгчдийг хамруулах боломжийг нэмэгдүүлнэ.	Секц дугуйлангийн тоо	10	14	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод, бусад байгууллагууд	II-IV улирал

	1	2	3	4	5	6	7
2. Үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд:							
2.1.	Нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа спортын заалтай байгууллагуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тодорхой цаг гарган үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна.	Үйлчилгээ үзүүлсэн спорт заалтай байгууллагын тоо	16	20	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод	II-IV улирал
2.2.	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт хүүхэд залуус, иргэдийг спортын тэмцээн, уралдаанд тэгш хамруулах ажлыг зохион байгуулна.	Нийслэл, дүүргийн тэмцээнд, уралдаанд оролцогчдын тоо	2400	2500	Нийслэлийн Биеийн тамир, спортын газар	Дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод, бусад байгууллагууд	II-IV улирал

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

САНАЛ БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



С САРАНЦЭЦЭГ

Г БЯМБАСАЙХАН